

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сосорын Дагва	Дугаар	L008
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Дундговь аймгийн Сайнцагаан сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дайчин бэйсийн хошууны Мөхийн жас	Сүм хийдийн дугаар	ДУСЦ 046
Одоогийн сүм хийд	Манба дацан	Сүм хийдийн дугаар	УВ 05
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 1-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Сайнцагаан сумын Мөхийн жас

Таван настайдаа Ширээт лам ахыгаа даган Мөхийн жас дээр ном заалган шавилан суусан. Найман насандаа Цогчэн магтаал төгсөж, Дэлгэрийн чойр дээр ахынхаа хамт ирж Хангал төгсөөд, чойр эхлэн, 1925 онд ахынхаа хамт Богдын хүрээнд ирсэн. 1935 онд домын дамжаа барьж гэвш болсон. Монгол оронд Сталины харгис дэглэм ноёрхож, улсын хэмжээгээр лам нарыг дээд, дунд, доод гэж 3 ангилан, лам бүрээс 200-2000 мөнгөн янчааны албан татвар авдаг болсон байсан бөгөөд 200 янчааны татвар төлж чадахгүй учраас хар болсон. Лам байхдаа 1933, 1934 оноос Хятадын 2-р гудамжинд ажиллаж байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөхийн жасыг XVIII зууны сүүлчээр 1780-аад оны үед алс холоос ирсэн Доёд гэдэг халзан лам байгуулан хөгжүүлсэн юм. Тэр хүн Гүмбэн, Лавран, Баруун зууд шавилан сууж ном үзэж яваад нутаг буцах замдаа манай Мөхийн тэрүүгээр явсан. Тэнд хийд байгаагүй. Уулын зүүн талд Зүүн ханангийн агуйд 2, 3 жил нямбанд суугаад ойрын нутгийнхан түүнд шавь орсон юм гэнэ лээ. Тэгээд нутаг буцалгүй тэндээ хийд байгуулсан нь Мөхийн хийд болсон юм. Тэр хүн 60 гараад Харь холын халзан ширээт лам гэж нэрлэгдэн 62 хүрч таалал төгсчээ.

Түүний 2-р дүрийг 1845 онд Мөхийн харь холын халзан ширээт гэдэг нэрээр залж Мөхийн жасын хамбын ширээнд суулгажээ. Тэр лам хошуу нутагтаа ном, эрдэм, шид, чадлаараа гайхагдсан сайн лам байгаад 1906 онд 61 настайдаа таалал төгсжээ.

Мөхийн Ширээт лам Мэндбаяр нь тэр үеийн Богд хан уулын аймаг Адаацаг сумын нутаг Ширгүүний говийн хойдох Хужирт Хонхор гэдэг газар 1910 онд Төмөр нохой жилийн намрын тэргүүн бич сарын 18-нд эх Пэлжээгийн 3-р хүү болон төрсөн. Эцэг нь сэргэлэн Шийрав гэдэг их номтой лам байсан. Тэр үед лам хүнээр овоглуулдаггүй байсан учраас эхийн төрсөн эгч Сосороор овоглуулсан юм. Мэндбаяр хүүг гурван настайд нь Мөхийн хийдийн харь холын халзан ширээт ламын 3-р дүрээр VIII богдоос сунтаг шүүлгэн тодруулж, байнгын багш өвгөн Ханд ламд гардуулан асруулжээ. 5 нас хүрмэгц төвд ном зааж Мөхийн хувилгаан ламын ширээнд залж, Богдын айлдсан Жамьяндоми гэдэг нэрээр нэрлэсэн. Жамьяндоми хувилгаан 10 нас хүртлээ өөрийн ном заалгасан багшаар Цогчэн магтаал, шашин хурлын дэг горим, зарчимд гарамгай суралцаж, улмаар чойрын хамба лам Заваа Дамдинд шавь орж Чойр нэр, Жүд, Лүн Ван хүртсэн. Жамьяндоми ламтан 1921 онд хүрээнд очиж Дагдан аграмбад шавь орж Чойрын ном заалгаж арван толгойн зэрэгт хүрч 1930 онд лянх дом хуруулж, домын дамжаа барьж сайн гэвш болж шалгарсан учраас 1932 онд Дэлгэрийн Чойр дээр 23 настайдаа гавьжийн дамжаа барьсан юм. Ширээт гавж бурханы номыг сайн эзэмшсэнээрээ Хүрээнд Номч мэргэн хутагт, Харь холын халзан ширээт лам гэж алдаршсан. Тийм ч учраас Ширээт ламыг жил бүрийн цагаан сарын 14-ний ерөөлөөр хүндэтгэж их Цогчэн дуганд Дилав хутагтын дараах түншлэгтэй ямбанд суулгадаг байжээ. Ширээт ламыг Эрдэнэ зуу, Баруун хүрээ, Далай гүний хүрээ, Мишиг гүний хүрээ болон өөрийн хошууны бүх жасуудаар залж ном айлдуулж, хуралдаа хуруулж байсныг би өөрөө байнга дагаж цуг явдаг учраас мэдэж байгаа юм. Ширээт ламыг хувилгаан, том толгой харгис гэж 1932 онд түүний хурал номын бүх хэрэглэл, хөрөнгийг хурааж баривчлах гэсэн боловч өвчтэй хэвтэрт байсан учраас орхисон. Миний ах Жамьяндоми 1934 онд таалал төгссөн. Бид Ширээт ламын алдарыг мөнхжүүлэхийн тулд Дундговь аймгийн төвийн хийдэд бурхан бүтээж, суварга босгож, Ширээт ламын байнгын сан байгуулсан юм. Жил бүрийн 9-р сарын 1-ний өдөр Ширээт ламын дайчид тогтмол хурдаг байхаар тогтсон.

Мөхийн жас байнга суудаг 20 гаруй ламтай, байнгын хуралтай олон үедээ 150 лам суудаг, 4, 5 дугантай хурлын газар байсан. Цогчэн, Чойнхорлин, Зод, Ширээт ламын дуган гэсэн дугануудтай байсан. Хийдийн хамба нь Ширээт ламын багш нь байсан. Ловон нь нэг эмч байсан. Манайхан ловон багш гэдэг. Хийдийнхэн бүгдээрээ

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шавь нь байсан тийм хүн байсан. Тэнд Сэтээ гэлэн гуай, Дэлэг гэлэн гуай, Минжүүр гэлэн гуай гэсэн 4, 5 хүмүүс байнга сууж, хүүхдэд ном зааж байдаг байсан.

Дуганууд нь хятад маягийн тоосгон дугантай байсан. Том дуган нь манай Манба дацангийн дугантай адил. Жижиг нь Гандангийн Дүйнхорын дуганын хэлбэртэй. Ламын сүм нь жаахан тийм дуган байсан. Зодын дуган горооны гадна 300-аад м-н зайтай байдаг байсан.

Мөхийн уул гэж хадтай бага уул бий. Хойд талд Бага газрын чулуутай. Мөхийн уулыг тахидаг. Зуны дунд сарын дунд хавиар тахидаг байсан. Баруун цагаан чулууг тахидаг байсан. Эргэн тойрондоо баруун талд нь Дугантын жас, баруун хойд талд нь Зуутын жас, Хорины жас, хойд талдаа Тавийн жас тэгээд Дэлгэрийн Чойр гээд байсан. Манай хошуунд байсан 20-иод сүм хийдийн голд нь байсан юм. Ойролцоо Ганжуур, Дугант, Нарангийн лам нар илүү их харилцаатай байсан. Наран, Ганжуур хоёр бол илүү их харилцаатай нийлж хурдаг байсан. Дэлгэрийн Чойроос урагш байдаг хийдүүдийн хамгийн хойд талынх нь юм. Цам гардаг, майдар эргэдэг, байнгын цогчэн хурдаг, хуучин номын үед Дарь эхийн хурлаа хурдаг, хайлан хийдэг, Дүйнхорын дүлцон хурдаг, дүнчүүр маанийн бүтээл хурдаг, нүгнээ сахидаг, цөөн ламтай боловч нэлээд хөгжсөн газар байсан юмаа. Цам зуны адаг сарын 10, 29-нд гардаг. 10-аад шахуу дүр гардаг Мялын цам гардаг байсан.

Хийдийн гол шүтээн нь Лхам, Чойжоо. Лам нар нь ойр хавиасаа сууна. Хийдэд бартай байсан. Доржзовд, Сандуйн жүд, Дарь эх гэсэн номнуудыг сүсэгтнүүдийн хүсэлтээр барладаг байсан. Бар нь тусгай жижигхэн дугантай байсан.

Цогчэн өдөр бүр байнга хурна. Өвөлдөө Хангал, зундаа хайлан хийнэ. Манлын дүлцон хурна. Хавар нүгнээ сахина. Тусгай тусгай хугацаатай. Маргааш тийм хуралтай гэхэд л лам нар нь цуглачихна. Зарлаад байх юм байхгүй. Майдар 5 сарын дундуур эргэнэ. Ганжуур тогтмол айлтгалаар хурна. Мөн эргэнэ. Ганжууртай, Данжууртай ном төхөөрөмжийн тал дээр гайхамшигтай байсан юм. Манайд сургалтын ямар нэгэн дацан байгаагүй. Чойрт бол Дэлгэрийн Чойр руу явна.

Хийд дээрээ байнга суудаг лам нарынх гээд 10 гаруй айл байсан.

Манайд 3, 4 жас гэж байсан. Ширээт ламын, Чойнхорлингийн гээд л байсан. Манайд зодын хурал байсан. Тэр дуган манайд хамаарна. 20, 30 лам байсан. Байнгын тэндээ байхгүй. Сар бүрийн 25-нд цуглана. Зулын 25-нд их хурлаа хурдаг тиймэрхүү л газар байсан юм.

Мөх 1937 онд хаагдсан. Хаагдахаас өмнө лам нар нь баригдсан.

Дэлгэрийн Чойрт би 2,3 жил байсан. Дэлгэрийн чойр бол гүн ухааны газар. Энд миний багш Тэгшийн жас дээр сууж байгаад тодорч гарсан гавж хүн байсан. Манба, зурхай, чойр зэрэг дугантай. 4 аймагтай байсан. Манай зиндаа 30-аад ламтай байсан. Чойрт Банчэн ламын болон Гүнчэн ламын гэсэн хоёр игчаа хоёул байсан. Би Гүнчэн ламын игчаагаар ном үзсэн. Ер нь Дэлгэрийн чойрт 500-аад лам байсан. Би тэнд жумбарайн зиндаа хүртэл яваад Хүрээнд ирсэн. Хүрээнд ирээд мөн л хадгийн зиндаанаас эхэлсэн. Тэнд 9 жил суусан. Нохой жил буюу 1935 онд манай зиндааны нийт 384 хүн дом тавьсан. Дашчоймбэлийн түүхэнд хамгийн олон хүн домын дамжаа барьсан нь тэр байсан. Хамгийн олон ламтай нь Дашчоймбэл, хамгийн баян нь Гунгаачойлин, хамгийн

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

цөөн ламтай нь Идгаа байсан юм. Би Хүрээнд ирээд Тойсамлин аймагт аймаглаж байсан. Тэнд 2,3 жил болсон байх. Аймгийн дацан ердийн өдөр тутмын хурал хурна. Манай аймгаас Гунгаачойлингийн шунлайв болж байсан. Тэр шунлайв бол Дайчин бэйсийн хошууны Зуут жасаас гарсан Дагдансүрэн гэж лам байсан юм. Одоогийн Дундговийн аймгийн төв байгаа газарт байсан Зуугийн жасаас гарсан Довууч гавж гэдэг хүн Цогчэн их гэсгүй байсан юм. Тэгштийн жасаас төрсөн Пунцагдаш гавж гэдэг хүн Дашчоймбэлийн их гэсгүй байсан юм. Энэ мэтийн миндагтангууд, Хүрээнд тодорсон хүмүүс их байсан. Манай Дайчин бэйсээс гавжийн дамжаа барьсан, аграмбын дамжаа барьсан, маарамбын дамжаа барьсан олон хүн төрж гарсан байдаг юм.